

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд худалдан авсан үндсэн хөрөнгөд төлсөн татварыг 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн дагуу хувь тэнцүүлэн хасагдуулж тооцно.

2 дугаар зүйл. 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд хамаарах ногдуулалт болон төлөлт, буцаан олголт, урамшуулал, хойшлуулан бүртгэсэн татвартай холбоотой харилцааг 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг баримтлан тодорхойлно.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 22.1-д заасан хугацаанд хүсэлт гаргаагүй, 2027 онд татвар ногдох орлогогүй, борлуулалтын орлого нь 50 сая төгрөгт хүрээгүй, чөлөөлөгдсөн бараа, ажил, үйлчилгээ үзүүлдэг татвар суутган төлөгч бус этгээдийг татварын алба хялбаршуулсан горимд бүртгэж татвар төлөгчид мэдэгдэнэ.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт, 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт, 12 дугаар зүйлийн 12.10 дахь хэсэгт, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсэгт, заасан захиргааны хэм хэмжээний актыг холбогдох эрх бүхий этгээд 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор батална.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

МЭРГЭЖЛИЙН НЭГДСЭН ХОЛБООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Мэргэжлийн нэгдсэн холбоодын эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 8.2-т” гэснийг “Татварын ерөнхий хуульд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.2.12 дахь заалтын “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.21-д” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 6.1.52-т” гэж, 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 4.1.14-т” гэснийг “Татварын ерөнхий хуулийн 6.1.57-д” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... сарын ... өдөр

Улаанбаатар хот

ХОТЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хотын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “10.2-т заасан журмын” гэснийг “9 дүгээр зүйлд заасны” гэж, 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийн “Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай” гэснийг “Татварын ерөнхий” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2009 оны 10 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дүгээр зүйл. Энэ хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС
ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. 2012 оны 05 дугаар сарын 22-ны өдөр батлагдсан Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас, дотоодод шинээр үйлдвэрлэсэн инновацийн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний борлуулалтын орлогыг нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус” гэснийг “гаалийн албан татвараас” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дүгээр зүйл. Энэ хуулийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОНЦГОЙ АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.10 дахь хэсэг нэмсүгэй:

“6.10.Импортлолсон суудлын автомашины гаалийн үнийн 100.0 мянган америк доллароос давсан хэсэгт энэ хуулийн 6.3 дахь хэсэгт заасан хэмжээн дээр нэмж 33 хувийн онцгой албан татвар ногдуулна.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оныдугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг:

“5.3.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9.1.5-д заасны дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар ногдуулах үнэлгээг тодорхойлоход Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.2.10-т заасан журам, аргачлалыг баримтална.”

2/7 дугаар зүйлийн 7.8, 7.9 дэх хэсэг:

“7.8.Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 13.1.8-д заасны дагуу баталсан түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хадгалж, хамгаалж буй үл хөдлөх эд хөрөнгийг хадгалж, хамгаалж буй хугацаанд нь албан татвараас 100 хувиар хөнгөлнө.

7.9.Энэ хуулийн 7.1.2-т заасан албан татвараас чөлөөлөх орон сууцны үнэлгээний дээд хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөл тогтооно.”

2 дугаар зүйл. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.2.иргэний өмчилж байгаа аймаг, сум, нийслэлийн харьяа хотоос бусад улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот дахь орон сууц, нийслэл, нийслэлийн харьяа хот дахь хоёр орон сууцны үнэлгээнээс аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн тогтоосон үнийн дүн хүртэлх хэсгийг;”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг